ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зүүнбаян Сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/69/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор: У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1 Оршил ........ 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ .5

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 9

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .... 9

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........

2.11. Шилэн дансны мэдээлэл ........ 9

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 9

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........

3 Менежментийн захидал

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.12 № 1-6/51

танай______________-ны №______________-т

ЗҮҮНБАЯН ДАХЬ СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ДАРГА Ц.БОЛОРМАА ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрхлэгч Болормаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Зүүнбаян дахь Сум дундын эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Зүүнбаян дахь Сум дундын эмнэлэг 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.04-нөөс 2020.02.05–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын Зүүнбаян дахь Сум дундын эмнэлэг нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020.02.24-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх журам төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

***Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн*** үйл ажиллагааны эрхэм зорилго нь ***Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг стандартын түвшинд аюулгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай үзүүлэхэд*** оршино.

***Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн*** үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ***Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ***
- ***Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ***
- ***Дэмжих үйлчилгээ***

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолд заасан

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус ***Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн*** мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

***Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн*** нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд acolous программ хангамж ашигладаг байна.

***Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн*** дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар ***Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн*** бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн Цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “их, дунд, бага/” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 586807.3 мянган төгрөгөөс тооцон 5868,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4005.5 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн тайлангаарх хамгийн бага үзүүлэлт болох нийт зардлын 1 хувиар сонгосонтой холбоотой болно.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

***Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн*** 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 176413.8 мянган төгрөгөөр буюу 23 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 2593.8 | 129.2 | -2464.6 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 17782.8 | 39390.3 | 21607.5 |
| Үндсэн хөрөнгө | 568893.7 | 726164.5 | 157270.8 |
| **Нийт хөрөнгө** | 589270.3 | 765684.1 | 176413.8 |
| Өр төлбөр | 573.5 | - | 573.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 671513.6 | 671513.6 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 589270.3 | 765684.1 | 176413.8 |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. 2018 онд үүссэн Чандмань –Илч ХХК–аас 2353.7, ажилтнаас авах авлага 240.0 мянган төгрөг нийт 2593.8 мянган төгрөгийн авлага бүгд барагдсан. Харин 2019 онд ХХОАТ-ын татварын хөнгөлөлтийн зөрүүгээр 129.2 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд эм боох материалын төлөвлөгөө 16,000.0 мянган төгрөгөөр, Хоол, хүнс 2,000.0 мянган төгрөгөөр, шатахуун 1702,2 мянган төгрөгөөр нэмж батлагдсантай холбоотой бөгөөд 2019 оны 5,6,7 сард тус эмнэлгийн байр засварт орж нэн шаардлагатай өвчтөнг хэвтүүлэн эмчилж байсан тул хоол, хүнс эм тарианы гүйцэтгэл бага гарч үлдэгдэл өмнөх оноос нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь үнэ төлбөргүй болон хандиваар барилга байгууламж сайжруулалт 150256.2 мянган төгрөг УАЗ фургон 31500,0 мянган төгрөг нийт 181,756.2 мянган төгрөгөөр, төсвийн хөрөнгөөр тавилга эд хогшил 4216.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 1890.0 мянган төгрөг, программ хангамж 275.0 мянган төгрөг 6,381.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 765,684.1 мянган төгрөг болж 176,987.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үед 176987.3 мянган төгрөгийн ашигтай ажилласнаас шалтгаалжээ. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй

### 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Зүүнбаян дахь сум дундын эмнэлэг тайлант онд 393,754.4 төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр 393,293.2 мянган төгрөгийн санхүүжилт орж 99,9 хувьтай байна.

*Хүснэгт 2. Санхүүжилт* /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Улсын төсвөөс санхүүжих | 358,018.1 | 358,018.1 | 0.0 | 100 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 35,736.3 | 35,668.4 | 67.9 | 99.8 |
| **Нийт дүн** | 393,754.4 | 393,293.2 | 67.9 | 99.9 |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 393,754.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 393,754.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан бөгөөд нийт гүйцэтгэл 393,293.2 мянган төгрөг байна.

Нийт зардлын 358,018.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 35,736.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Цалин хөлс болон нэмэгдэл, урамшлын зардлын төлөвлөгөө 215,432.2 мянган төгрөг гүйцэтгэл 215435.5 мянган төгрөг буюу 1.6 мянган төгрөгөөр хэмнэсэн, Ажил олгогчоос төлөх НДШимтгэл 17.8 мянган төгрөгөөр, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 400.2 мянган төгрөгөөр Нормативт зардал 0.1 мянган төгрөгөөр Томилолтын зардал 1.4 мянган төгрөгөөр,Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 36.7 мянган төгрөгөөр бараа ажил үйлчилгээний бусад зардал 2.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 393,293.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт дансанд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан Хандив тусламж 227.0 мянган төгрөг / сумын эмч нарын холбоо сорьц тээвэрлэлтийн зардал /, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1743.0 мянга / элэгний ВС вирусын оношлуур/, нийт 1970.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Урсгал зардалд 1663.0 мянга, БГАҮ төлбөрт 80,0 мянга, Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулалд 187.9 мянга,Нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 39.1 нийт 1970.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0 үлдсэн байна.

### 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2722.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 716.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2006.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2019 Интернэтийн төлбөрийг батлагдсан төсөвт суулгаж өгөөгүйгээс 2019 оны 12 сард төсвийн тодотголоор нэмж тодотгон 12 сард бөөнөөр нь төлсөн байна.

### 2.12. Шилэн дансны мэдээлэл

Сайншанд сумын Зүүнбаян дахь Сум дундын эмнэлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

### 2.12 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 2.4 сая төгрөгийг барагдуулсан байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зүүнбаян дахь Сум дундын эмнэлэг 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Зүүнбаян дахь Сум дундын эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Зардлын данстай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт: Түлш шатахууны зардлаас автомашины доторлогоо хийлгэж, суудлын бүрээс худалдан авсан зардлыг шилжүүлсэн*

1.2. *Эрсдэл: Тухайн зардлын батлагдсан төсөв хэтрэх, гүйцэтгэл бодитоор илэрхийлэгдэхгүй*

1.3. *Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалд заасны дагуу зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх*

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **20,376,617.69** | **39,519,569.15** |
| **33** | **АВЛАГА** | 2,593,836.33 | 129,242.35 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 240,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 2,353,836.33 | 129,242.35 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,353,836.33 | 129,242.35 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 17,782,781.36 | 39,390,326.80 |
| **351** | **Түүхий эд материал** | 5,687,159.00 | 18,324,555.14 |
| 35130 | Эм боох материал | 5,687,159.00 | 18,324,555.14 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,095,622.36 | 21,065,771.66 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 232,000.00 | 795,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,245,282.36 | 9,569,381.56 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,722,844.90 | 1,481,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 373,797.10 | 4,697,992.10 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,521,698.00 | 4,521,698.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **568,893,777.42** | **726,164,555.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 568,893,777.42 | 726,164,555.88 |
| **392** | **Биет хөрөнгө** | 304,137,777.42 | 461,139,285.05 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 252,177,430.90 | 402,433,630.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -17,382,154.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19,988,300.00 | 50,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -19,988,300.00 | -18,937,500.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 106,462,386.00 | 83,408,786.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -76,459,403.64 | -60,221,936.89 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 32,997,909.00 | 36,693,909.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,476,969.69 | -15,232,573.97 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,005,500.00 | 1,005,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -794,175.15 | -853,475.19 |
| 39217 | Ном | 225,100.00 | 225,100.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 264,756,000.00 | 265,025,270.83 |
| 39301 | Програм хангамж | 385,000.00 | 660,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -385,000.00 | -390,729.17 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 264,756,000.00 | 264,756,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **589,270,395.11** | **765,684,125.03** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **573,529.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 573,529.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 573,529.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 571,909.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1,620.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,620.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **588,696,866.11** | **765,684,125.03** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 588,696,866.11 | 765,684,125.03 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 671,513,673.50 | 671,513,673.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 671,513,673.50 | 671,513,673.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -296,543,718.11 | -119,556,459.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -296,543,718.11 | -296,543,718.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 176,987,258.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 213,726,910.72 | 213,726,910.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **589,270,395.11** | **765,684,125.03** |

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **343,346,489.85** | **577,538,849.16** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **35,306,146.85** | **181,882,369.16** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 35,306,146.85 | 126,169.16 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 35,306,146.85 | 126,169.16 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 35,306,146.85 | 126,169.16 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 181,756,200.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 181,756,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **308,040,343.00** | **395,656,480.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 272,641,198.00 | 358,018,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 272,641,198.00 | 358,018,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 358,200.00 | 1,970,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 128,200.00 | 227,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 230,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 1,743,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 35,040,945.00 | 35,668,380.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 35,040,945.00 | 35,668,380.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 00.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **329,356,704.58** | **399,693,621.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **329,356,704.58** | **399,693,621.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 326,447,049.58 | 398,713,304.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 171,154,607.34 | 215,087,875.58 |
| 210101 | Үндсэн цалин | 166,972,450.34 | 215,087,875.58 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 432,000.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 3,750,157.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,542,591.04 | 27,372,142.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,674,662.89 | 18,216,762.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,233,303.00 | 2,143,143.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 887,443.66 | 1,714,511.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 390,909.00 | 411,223.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,356,272.49 | 4,886,503.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,761,344.00 | 58,385,380.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,576,000.00 | 2,300,745.55 |
| 210302 | Түлш, халаалт | 43,904,044.00 | 50,327,891.33 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,281,300.00 | 5,756,744.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,138,192.09 | 22,212,045.70 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 1,111,500.00 | 1,825,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,314,030.09 | 15,323,344.90 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 1,393,260.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 875,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,744,020.00 | 2,793,840.80 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,728,642.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,339,753.41 | 35,744,250.06 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 28,459,269.15 | 30,213,845.06 |
| 210502 | Хоол, хүнс | 4,159,084.26 | 4,010,505.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,721,400.00 | 1,519,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,040,390.00 | 3,704,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 78,100.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,962,290.00 | 3,704,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 660,000.00 | 1,484,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 660,000.00 | 1,484,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,677,610.00 | 2,883,067.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 309,100.00 | 343,440.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 876,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 206,190.00 | 180,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 53,010.00 | 44,110.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,403,155.00 | 71,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 184,055.00 | 772,917.60 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 100,000.00 | 165,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 152,100.00 | 410,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,132,561.70 | 31,839,942.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,241,480.00 | 1,831,490.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,891,081.70 | 30,008,452.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,909,655.00 | 980,316.73 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 587,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 187,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 399,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,909,655.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,909,655.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 393,316.73 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 393,316.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,989,785.27** | **177,845,227.56** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 857,968.64 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 857,968.64 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -857,968.64 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **13,989,785.27** | **176,987,258.92** |

## 4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **308,040,343.00** | **395,656,480.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **308,040,343.00** | **395,656,480.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 272,641,198.00 | 358,018,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 272,641,198.00 | 358,018,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 358,200.00 | 1,970,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 128,200.00 | 227,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 230,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 1,743,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 35,040,945.00 | 35,668,380.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 35,040,945.00 | 35,668,380.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **305,689,543.00** | **389,275,480.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **305,689,543.00** | **389,275,480.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **302,779,888.00** | **388,295,163.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 171,138,288.00 | 215,435,557.04 |
| 210101 | Үндсэн цалин | 110,963,104.34 | 139,402,063.56 |
| 210102 | Нэмэгдэл | 40,919,498.66 | 57,679,468.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,900,187.00 | 3,656,265.00 |
| 210104 | Урамшуулал | 10,355,498.00 | 14,697,760.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,821,000.00 | 27,485,547.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,880,600.00 | 17,776,047.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,735,100.00 | 2,427,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,388,100.00 | 1,941,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 347,000.00 | 485,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,470,200.00 | 4,854,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,937,800.00 | 56,031,609.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,576,000.00 | 2,300,745.55 |
| 210302 | Түлш, халаалт | 42,080,500.00 | 50,449,564.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,281,300.00 | 3,281,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,113,000.00 | 22,621,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 495,300.00 | 1,846,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,680,700.00 | 15,082,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 1,393,260.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,033,100.00 | 1,799,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 903,900.00 | 2,499,840.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,359,300.00 | 51,734,192.04 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 28,711,811.30 | 41,460,492.04 |
| 210502 | Хоол, хүнс | 3,447,488.70 | 7,773,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,200,000.00 | 2,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,349,200.00 | 6,272,620.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,149,200.00 | 1,446,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,200,000.00 | 4,826,120.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 660,000.00 | 1,484,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 660,000.00 | 1,484,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,441,300.00 | 3,272,967.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 309,100.00 | 348,440.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 876,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 206,190.00 | 180,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 53,010.00 | 44,110.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,782,000.00 | 131,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 221,000.00 | 772,917.60 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 100,000.00 | 100,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 500,000.00 | 800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,960,000.00 | 3,957,070.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,960,000.00 | 3,957,070.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,909,655.00** | **980,316.73** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 587,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 187,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 399,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,909,655.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,909,655.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 393,316.73 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 393,316.73 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,350,800.00** | **6,381,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,350,800.00** | **6,381,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,350,800.00** | **6,381,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,350,800.00 | 6,381,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,350,800.00 | 6,381,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2,350,800.00** | **-6,381,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 406,757,673.50 | 395,109,787.63 | -266,580,065.45 | 535,287,395.68 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 180,300.00 | 180,300.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **406,757,673.50** | **395,109,787.63** | **-266,399,765.45** | 535,467,695.68 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | -180,300.00 | 00.00 | -180,300.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -13,356,901.97 | -13,356,901.97 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **671,513,673.50** | **213,726,910.72** | **-296,543,718.11** | 588,696,866.11 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **671,513,673.50** | **213,726,910.72** | **-296,543,718.11** | 588,696,866.11 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **671,513,673.50** | **213,726,910.72** | **-296,543,718.11** | 588,696,866.11 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 176,987,258.92 | 176,987,258.92 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **671,513,673.50** | **213,726,910.72** | **-119,556,459.19** | 765,684,125.03 |

### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 393,754,400.00 | 393,293,163.27 | 461,236.73 | 99.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 393,754,400.00 | 393,293,163.27 | 461,236.73 | 99.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 393,394,400.00 | 392,933,163.27 | 461,236.73 | 99.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 215,437,200.00 | 215,435,557.04 | 1,642.96 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 138,688,500.00 | 139,402,063.56 | -713,563.56 | 100.5 |
| 210102 | Нэмэгдэл | 57,679,500.00 | 57,679,468.48 | 31.52 | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,158,000.00 | 3,656,265.00 | 501,735.00 | 87.9 |
| 210104 | Урамшуулал | 14,911,200.00 | 14,697,760.00 | 213,440.00 | 98.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,503,400.00 | 27,485,547.04 | 17,852.96 | 99.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,793,500.00 | 17,776,047.04 | 17,452.96 | 99.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,427,200.00 | 2,427,400.00 | -200.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,941,500.00 | 1,941,900.00 | -400.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 485,700.00 | 485,500.00 | 200.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,855,500.00 | 4,854,700.00 | 800.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 56,431,800.00 | 56,031,609.55 | 400,190.45 | 99.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,570,000.00 | 2,300,745.55 | 269,254.45 | 89.5 |
| 210302 | Түлш, халаалт | 50,580,500.00 | 50,449,564.00 | 130,936.00 | 99.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,281,300.00 | 3,281,300.00 | 0.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,621,500.00 | 22,621,500.00 | 0.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,516,800.00 | 1,846,600.00 | -329,800.00 | 121.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,411,400.00 | 15,082,000.00 | 329,400.00 | 97.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,393,300.00 | 1,393,260.00 | 40.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.00 | 1,799,800.00 | 200.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,500,000.00 | 2,499,840.00 | 160.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 52,659,300.00 | 52,659,192.04 | 107.96 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,909,300.00 | 42,385,492.04 | -2,476,192.04 | 106.2 |
| 210502 | Хоол, хүнс | 10,250,000.00 | 7,773,700.00 | 2,476,300.00 | 75.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,791,000.00 | 9,790,620.00 | 380.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,591,000.00 | 3,627,500.00 | -36,500.00 | 101.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210602 | Тавилга | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 00.00 | 0.00 | |
| 210604 | Урсгал засвар | 3,200,000.00 | 3,163,120.00 | 36,880.00 | 98.8 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,485,500.00 | 1,484,100.00 | 1,400.00 | 99.9 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 | 0.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,485,500.00 | 1,484,100.00 | 1,400.00 | 99.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,504,700.00 | 3,467,967.60 | 36,732.40 | 99.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 270,000.00 | 268,440.00 | 1,560.00 | 99.4 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 876,000.00 | 876,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 180,000.00 | 180,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,200.00 | 44,110.00 | 35,090.00 | 55.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 406,500.00 | 406,500.00 | 0.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 773,000.00 | 772,917.60 | 82.40 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 100,000.00 | 100,000.00 | 0.00 | 100.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3960000.00 | 3957070.00 | 2,930.00 | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,960,000.00 | 3,957,070.00 | 2,930.00 | 99.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 360,000.00 | 360,000.00 | 0.000 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 360,000.00 | 360,000.00 | 0.000 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 360,000.00 | 360,000.00 | 0.000 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 393,754,400.00 | 393,686,480.00 | 67,920.000 | 100.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 358,018,100.00 | 358,018,100.00 | 0.000 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 358,018,100.00 | 358,018,100.00 | 0.000 | 100.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 35,736,300.00 | 35,668,380.00 | 67,920.000 | 99.8 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 35,736,300.00 | 35,668,380.00 | 67,920.000 | 99.8 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 22.00 | 20.00 | 2.000 | 90.9 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.000 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.000 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 14.00 | 2.000 | 87.5 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 | 0.000 | |

### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,970,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,970,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,743,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,663,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,663,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 80,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 80,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 227,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 227,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 187,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 39,100.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1970000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,970,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 227,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,743,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |